

08

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:01

Улаанбаатар хот

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ :

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2015 оны 04 сарын 28-ны өдрийн тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Гүйцэтгэх захирлын тайланг баталсугай.
2. Компанийн 2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн стратеги, бизнес төлөвлөгөө, бизнес төсөл танилцуулгыг тус тус хавсралтаар батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ШИНЭЧЛЭСЭН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2015 оны 04-р сарын 28 –ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Шинэчлэсэн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

20

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:03

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2015 оны 04-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

00000039

11

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2015 оны 04 -р сарын 28–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Б.МӨНХБОЛОР
2. С.БАТБАЯР
3. Б.МӨНХБАЯР
4. Б.МӨНХБАТ
5. Б.МӨНХБОЛД
6. Ж.УНДРАА

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Ш.БАТЖАРГАЛ
2. Э.ЦЭНДСҮРЭН
3. Т.НАРАНХҮҮ

- 3.Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

00000040

2

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:05

Улаанбаатар хот

**КОМПАНИЙ ОНООСОН НЭР
ӨӨРЧЛӨЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2015 оны 04-р сарын 28 –ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаний оноосон нэрийг цаашид явуулах үйл ажиллагаатай холбогдуулан “**Е-МОНИЕ**” ХК болгон өөрчлөн баталсугай.
2. Компанийн нэрийн өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрсөний дараа компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай
3. Компаний нэрний өөрчлөлтийг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

73

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:06

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Жавхлант Хараа” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигч Н.Батчулуун /ГЗ40042776/ 11640 ширхэг, Б.Батболд /ГЗ74102574/ 3000 ширхэг нарын хувьцааг компани халааслан бүртгэж авсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

7

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд эрх шилжүүлэх тухай :

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Жавхланта Хараа” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас Тогтоох нь:

Компаний үйл ажиллагаа явууллагаа тогтворжуулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг 12 сарын хугацаатай Төлөөлөн удирдах зөвлөлд шилжүүлсүгэй.

Үүнд :

1. Компанийн тухай хуулийн 62 .1.2; 62.1.3; 62.1.6;62.1.8; 62.1.10; 62.1.12;

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

76

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:09

Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53.3 дүгээр заалт 2015 оны 04-р сарын 28–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хууль тогтоомжийн дагуу хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР

H

“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:10

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь заалт, “ЖАВХЛАНТ ХАРАА” ХК-ийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр явуулсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЖАВХЛАНТ ХАРАА” ХК-ийн засаглалыг сайжруулах хүрээнд компанийн засаглалын дотоод журмуудыг хавсралтаар баталсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралт №01

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг хавсралт № 02

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны журмыг хавсралт №03

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны журмыг хавсралт №04

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Цалин урамшууллын хорооны журмыг хавсралт №05

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмыг №06

Мэдээллийн үйл ажиллагааны журмыг №07

Ногдол ашгийг хувиарлах журмыг №08-аар тус тус баталсугай.

2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх захирал, нийт ажиллагсадад үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны 505 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журам”-ын 3.4-д заасаны дагуу мэдээллийг нийтэд тогтмол мэдээлэх ажилтанаар ТУЗ нарийн бичгийн дарга Э.Цэндсүрэнд томилсугай.

5. Дээрхи журмын дагуу нийтэд хүргэх мэдээллийн үнэн зөвд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал .Б.Мөнхбаярд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.БАТБАЯР